



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2023.11.16 № 32

Агаарын бохирдлыг бууруулах  
чиглэлээр авч хэрэгжүүлсэн  
арга хэмжээний талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан 2008-2023 оны хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль, тогтоол, шийдвэр тэдгээрийн хэрэгжилт, биелэлтийн талаар;
2. Агаарын бохирдлыг бууруулах асуудлаар 2008-2023 онд байгуулсан төрийн байгууллага, бүтэц нэгжүүд нь /Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо гэх мэт нэр нь өөрчлөгдөж байсан/ ямар эрх зүйн актаар байгуулагдсан болон түүний харьяалагдаж байсан байгууллага, удирдлага, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр байгуулсан байгууллага нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд байхад гүйцэтгэсэн ажил, зарцуулсан төсөв хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /2011-2013 он/;
4. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилт, зарцуулсан төсөв хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /2008-2023 он/;
5. Хагас коксын /зарим тогтоолд коксон түлш гэж бичигдсэн/ талаар тухайлан гаргасан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд тэдгээрийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл /2008-2023 он/;
6. Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн 14 дүгээр тогтоолын Нэгдүгээрт “Нүүрсийг дулааны аргаар боловсруулан коксон түлш үйлдвэрлэх ажлыг эрчимжүүлж, 2009 оны 8 дугаар сараас Улаанбаатар хотын гэр хорооллын хэрэгцээнд болон халаалтын зууханд коксон түлш нийлүүлэх ажлыг зохион байгуулахыг Түлш, эрчим

2023000118

хүчний сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай” гэсэн заалтын хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл;

7. Тус тогтоолын зургаадугаар заалтаар байгуулагдсан Түлш, эрчим хүчний сайд Ч.Хүрэлбаатарын ахалсан Үндэсний хорооны хийсэн ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл /"Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтад дор дурдсан агуулга бүхий 48 дахь заалтыг нэмсүгэй: 48. Агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороо -Түлш, эрчим хүчний сайд/;
8. Хагас коксын үйлдвэр байгуулах талаар 2010 оны 07 дугаар сарын 09-ний өдөр ТЭХЯ-ны холбогдох аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээгээр 2012 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулахаар заасан 210 мянган тонн хагас кокс үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр яагаад өнөөг хүртэл ашиглалтад ороогүй талаарх мэдээлэл;
9. Хагас коксын үйлдвэр барихаар төсвөөс 17 тэрбум төгрөг авсан “Аморе интернэшнл” компани буцааж төлсөн эсэх, /Төлсөн бол он дараалалтай нь ирүүлэх/;
10. Засгийн газрын 2014 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 161 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар;
11. Айл өрхүүдэд хэрэглэж буй сайжруулсан түлшний /Мидлинг/ найрлага, чанарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, мөн зарцуулсан төсөв хөрөнгө, өр төлбөртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл;
12. Сайжруулсан түлшийг /Мидлинг/ одоо хэрэглэж байгаа эсэх, цаашид хэрэглэх эсэх талаар;
13. Агаарын бохирдлыг бууруулахын тулд өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын гэр хорооллыг бүрэн хангахад хэчнээн хэмжээний хагас кокс хэрэгтэй байгаа талаарх тооцоо, судалгааны дэлгэрэнгүй мэдээлэл;
14. БНХАУ-аас хэчнээн хэмжээний хагас коксыг ямар үнээр авах гэж байгаа болон энэ нь гэр хорооллын айл өрхийн хэдэн хувийг хангах, үлдсэн айл өрхүүд энэ өвөл ямар түлш хэрэглэх талаарх мэдээлэл;
15. Агаарын чанарын үзүүлэлтийг ямар параметруудээр Улаанбаатар хотын хэчнээн цэгт хэмжиж байгаа талаар;
16. Параметруудийг тооцоолон гаргаж буй аргачлалыг хэзээ, хэдэн удаа өөрчилсөн талаар;
17. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний талаар;


2023000118

18. Энэ өвөл иргэд, хүүхдүүдийг агаарын бохирдлоос хамгаалахын тулд Засгийн газраас гаргасан зөвлөмж бий эсэх /Сурагчдын өвлийн амралтын талаар/ зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье. Асуулгын хариуг мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Н.АЛТАНХУЯГ

.. 2023000118